



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 14 өдөр

Дугаар 140

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаан бурхан өвчний дэгдэлтийн үед Засгийн газрын нөөц сангаас хуваарилсан төсвөөс Сангийн сайдын 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 1907 тоот албан тоотын 1 дүгээр заалт Халдваргүйтгэлийн бодис 60.300 мянга, 3 дугаар заалт эм, эмнэлгийн хэрэгсэл 53.626,0 мянга, 5 дугаар заалт нөхөн болон нэмэлт дархлаажуулалтад 94.960,0 мянган төгрөг нийт 208.886,0 мянган төгрөг /Хоёр зуун найман сая найман зуун наян зургаан мянган төгрөг/-ийн эм, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын, шууд гэрээ байгуулах, тендер зарлах, үнэлэх, гэрээ байгуулах эрхийг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дарга /Д.Нямхүү/-д шилжүүлсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү эдийн засгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Баярсайхан/-д үүрэг болгосугай.

САЙД



Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080487